ҮАГ-ын харьяа
СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

“МУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь хэрэгжилт”сэдэвт нийцлийн аудитын тайлан

Ерөнхий Дүгнэлт:

Хогийн хонхорын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах, уг газраас хайрга олборлох ажлыг эхлүүлэхээс өмнө холбогдох хууль тогтоомжийг бүрэн судлаагүй, өөр хоорондоо холбоотой 2 ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг нэгтгэж авч үзээгүй, сумын ИТХ-аас шийдвэр гаргуулж, гүйцэтгэх арга замаа зөв тодорхойлоогүй болон албан ёсны бичиг баримтууд утга санаа, цаг хугацааны хувьд зөрчилдөж байгаа зэрэг нь сумын удирдлагууд, иргэдийн хоорондмаргаан гарах нөхцөлийг үүсгэжээ.

Иймээс улсын хэмжээний мэргэжлийн байгууллагуудын байцаагч, шинжээчдийн багийг ажиллуулан Хогийн хонхор гэдэг газар нь ундны усны эх үүсвэр мөн эсэх, энэ нь бохирдсон эсэх, хайрга олборлосон нүхэнд хог хаягдал булсан эсэхэд нарийвчилсан шинжилгээ хийлгэж үүсээд буй маргаанд эцэслэсэн хариу өгүүлэх нь зүйтэй.

Сүхбаатар сум **2014 он**

Тайланг бэлтгэсэн: Сэлэнгэ аймгийн Аудитын газар **Тэргүүлэх аудитор** Ч.Энхтуяа **Аудитын менежер** Б.Батмөнх ***Шинжээч*** С.Баасансүрэн **2014 оны 02 дугаар сар** Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70363036,70363047,70363040 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. **ХАЯГ**:Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд	**АГУУЛГА** **Нэг. Товчилсон үгийн тайлбар** **Хоёр. Ерөнхий зүйл /Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй/** **Гурав. Аудитын дүн** ***1. Байгаль орчны холбогдолтой хууль, тогтоомжийг хэрэгжүүлж байна уу?*** 1.1. Аюултай хог хаягдлыг “Хогийн хонхор” хэмээх газарт ундны болон гүний усны эх үүсвэрт булшилсан эсэх. 1.2. Их хэмжээний хайргыг хууль бусаар олборлосон уу? ***2. Орон нутгийн хөгжлийн сан болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжуудын дагуу зарцуулсан эсэх.*** 2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байна уу. 2.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх. **3 Авлигын эсрэг болон НАНБХАСЗАСЗУСТ хуулийн хэрэгжилтийг хангаж байна уу** 3.1. Сумын засаг даргын албан тушаалд томилогдохын тулд холбогдох хүмүүст албан тушаал амалж, саналыг нь худалдаж авсан эсэх. **Дөрөв. Зөрчил** **Тав. Зөвлөмж**..... **Зургаа. Байгууллагаас ирүүлсэн санал, түүнд өгсөн тайлбар.**

Нэг. Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар.
НАНБХАСЗАСЗУСТ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХААЖДҮГ	Хүнс ,хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1 *Аудитын нэр:*

МУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь хэрэгжилт.

2. *Аудитын код:*

СЭАГ-2014/01-НА

3. *Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:*

МУ-ын Ерөнхий аудиторт УИХ-ын гишүүн О.Баасанхүүгийн 2014 оны 01-р сарын 20-ний өдрийн 7/506 тоотоор ирүүлсэн албан бичгийг үндэслэн МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ.

4. *Аудитын зорилт:*

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төр захиргааны байгууллага, холбогдох албан тушаалтнууд МУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг зөрчиж байгаа талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийн үндэслэлийг газар дээр нь шалгаж үнэлэлт дүгнэлт өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтын хүрээнд дараахь чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгөв.

Үүнд:

1. **Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна уу?**

1.1 Аюултай хог хаягдлыг "Хогийн хонхор" хэмээх газарт ундны болон гүний усны эх үүсвэрт булшилсан эсэх.

1.2 Их хэмжээний хайргыг хууль бусаар олборлосон уу?

2. **Орон нутгийн хөгжлийн сан болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжуудын дагуу зарцуулсан эсэх.**

2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байна уу.

2.2 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх.

3. **Авлигын эсрэг болон НАНБХАСЗАСЗУСТ хуулийн хэрэгжилтийг хангаж байна уу**

3.1. Сумын засаг даргын албан тушаалд томилогдохын тулд холбогдох хүмүүст албан тушаал амалж , саналыг нь худалдаж авсан эсэх.

5. *Аудитын хамрах хүрээ:*

Аудитад Сэлэнгэ аймгийн Шаамар сумын байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, түгээмэл тархацтай байгалийн баялгийн төлбөр хураамжийн төлөлтийн байдал, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгийн зарцуулалт болон бусад баримт материал,мэдээллийн эх сурвалжуудыг хамруулав.

6. Үндсэн мэдээлэл

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын оршин суугч хэсэг иргэдээс" Шаамар сумын удирдлагууд нь МУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, ТБОНӨБАҮХАТ хууль, Авилгын эсрэг хууль болон бусад хууль, тогтоомжийг зөрчиж байгаа"-г шалгуулах хүсэлт гаргаж Их хурлын гишүүн О.Баасанхүүд өргөдөл ирүүлжээ***.***

УИХ-ын гишүүн О.Баасанхүү нь МУ-ын ерөнхий аудитор А.Зангадад уг өргөдөлийн дагуу аудит хийж хариу өгөх тухай 2014 оны 7/506 тоот албан бичиг ирүүлсэн байна.

7. Аудитын эрсдэл.

Аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг" Дунд" гэж үнэллээ.

8. *Аудитын арга зүй:*

Аудитын явцад аудитын олон улсын стандарт,төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж,санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар Шаамар сумын Нутгийн удирдлагын болон Төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

9. Ш*алгуур үзүүлэлтүүд:*

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана.

МУ-ын Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн

тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Авлигын эсрэг хууль, НАНБХАШЗАСЗУСТухай хууль болон сумын ИТХ-ын тогтоол, засаг даргын захирамж зэрэг бусад хууль эрхийн актууд.

10. *Аудит хийх бүрэлдэхүүн:*

Аудитыг аймгийн тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх чанарын хяналтыг хэрэгжүүлэн, шинжээч С.Баасансүрэн хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

11. Аудит хийх хугацаа:

Аудитыг 2014 оны 01 сарын 29-нд эхэлж, тайлагналын үйл ажиллагааг 2014 оны 02 сарын 27-нд дуусгалаа.

Гурав. АУДИТЫН ДҮН

1. Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна уу.

1.1 *Аюултай хог хаягдлыг “Хогийн хонхор” хэмээх газарт ундны болон гүний усны эх үүсвэрт булшилсан эсэх, энэ нь байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн үү .*

Шаамар сумын Дэлгэрхааны 1-р багийн нутаг дэвсгэр Шар хайлаастын Хогийн хонхор хэмээх газар нь олон жилийн өмнөөс хог хаягдал хаяж эхэлсэн хур хогийн цэг юм.

МУ-ын Хог хаягдлын тухай хуулийн 8.4.1 *“Сум, дүүргийн Засаг дарга нь сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу хог хаягдлыг устгах цэг болон хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоох”* гэсэн бүрэн эрхийн хүрээнд Шаамар сумын Засаг даргаар ажиллаж байсан Д.Бямбасүрэнгийн 2010 оны 04-р сарын 02-ны өдрийн 66 тоот захирамжаар ” Дэлгэ*рхааны 1-р багийн нутаг дэвсгэр Шар хайлаастын хонхорт 3 га газрыг Нийтийн хогийн цэгийн зориулалтаар олгож, хогийг ангилан ялгаж боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр зохицуулан эзэмшүүлэх”*-ээр болж тус газрыг Шаамар сумын албан ёсны төвлөрсөн хогийн цэг болгожээ.

Аудитын явцад тус сумын засаг даргаар ажиллаж байсан Д.Бямбасүрэнгээс асуулга авахад: “ Бид 2012 онд Хогийн цэгээс хайрга олборлуулах, хур хог хаягдлыг цэвэрлүүлэх талаар Өгөөмөр баянбулаг ХХК-тай гэрээ байгуулан зохих ажлыг эхлүүлсэн боловч сумын иргэд эсэргүүцэл гаргасан тул эхэлсэн ажлаа зогсоосон болно” гэсэн тайлбарыг өгч байлаа. / *Засаг дарга Д.Бямбасүрэнгийн зүгээс Өгөөмөр баянбулаг компанитай байгуулсан гэх гэрээ нь архивлаж хадгалагдаагүй учир Аудитын газрын зүгээс гэрээтэй танилцах боломжгүй байв. /*

Шаамар сумын засаг даргаар томилогдсон М.Баярбаатар нь 2013 оны 04 сарын 22- ны өдрийн 1/54 тоот албан бичгээр” *Тус сумын хогийн төвлөрсөн цэгт байгаа хог хаягдлыг нүх ухан булшлах шаардлагатай болсон тул байгаль орчны ерөнхий үнэлгээ хийж манай ажилд тусална уу* “ гэсэн хүсэлтийг аймгийн БОАЖГ-т ирүүлсний дагуу 2013 оны 05 сарын 17-ны өдрийн 12 тоотоор *“Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1-р баг Шар хайлаастын хонхорт 3 га газарт төвлөрсөн хогийн цэг байгуулахад байгаль орчинд сөргөөр нөлөөлөх ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй, шууд хэрэгжүүлэх боломжтой төсөл гэж үзэж байна”* гэсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг өгчээ.

Дээрхи 2 албан бичгээс үзэхэд : Шаамар сумаас ” хог хаягдлыг нүх ухан булшлах “ ажилд байгаль орчны үнэлгээ хийлгэх хүсэлт ирүүлсэн байхад БОАЖГ –аас уг газарт “ төвлөрсөн хогийн цэг байгуулахад байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй, шууд хэрэгжүүлж болно” гэж үнэлгээ өгсөн нь хогийг нүх ухаж булах эсэхэд бус тус газарт хогийн цэг байгуулж болох эсэхэд өгсөн бололтой. Гэтэл үүнээс өмнө буюу сумын засаг даргын 2010 оны 66 тоот захирамжаар Шар хайлаастын хонхорыг сумын албан ёсны хогийн цэг болгосон байдаг.

Үнэлгээний дүгнэлт гарахаас өмнө */ дүгнэлт 2013 оны 5 сарын 17- нд гарсан /* буюу 2013 оны 04 сарын 29- нд Шаамар сумын Засаг дарга М.Баярбаатар, “Өгөөмөр Баянбулаг” ХХК-ий захирал Р.Батболд нар *“Төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг булуулах, хашаажуулж стандартын дагуу болгох, 1-р багийн 7,8,9-р хэсгийн дундуур сайжруулсан зам тавих, ухмалын хайрга олборлох”* 01 тоот гэрээг баталсан байна.

“ Уг гэрээний нэр нь “... *хогийн цэгийн хог хаягдлыг булуулах, ухмалын хайрга олборлох*...” ,1.1-р заалтанд “ *төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг стандартын дагуу нүх ухаж булах...”* гэж гэрээний зорилгыг тодорхойлсон, 3.4-д “....*ухмалын хайрга тээвэрлэж*..” гэж заасан, аймгийн БОАЖГ-т хог хаягдлыг нүхэнд булшлах ажлын үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасан зэргээс үзэхэд хогийн цэгээс хайрга олборлох, ухагдсан нүхэнд хог хаягдал булах ажил хийгдэхээр байсан нь харагдаж байна.

Гэтэл сумын засаг даргын зүгээс “ Бид дээрхи гэрээнд дахин засвар оруулж хог хаягдыг нүхэнд булах бус далан босгож овоолох ажил хийхээр болсон. Энэ ажлын хүрээнд , 10-аад га газрыг бүрхсэн, 5700-6000 тн хог хаягдлыг техникийн хүчээр түрж цэвэрлэн, зөөвөрлөж том 36, жижиг 17 овоолго болгож, 460 м газрыг бетонон шон бүхий өргөст тороор хашаажуулсан ” гэж тайлбарлаж байгаа боловч залруулсан гэх гэрээ нь гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй байв.

Аудитын явцад биднийг Хогийн хонхор хэмээх газарт очиход засаг даргын хэлсэнчлэн тус газрыг нэг талаас нь бетонон шон бүхий өргөст тороор хашаалж, их хэмжээний хогийг түрж зөөвөрлөн хэд хэдэн овоолго үүсгэсэн байсан бөгөөд хайрга

авсан газарт цасан бүрхүүл тогтсон учраас хог хаягдал булсан эсэх нь тодорхойгүй байлаа.

Хогийн хонхор нь ундны усны эх үүсвэр мөн эсэх, хайрга олборлосон нүхэнд хог хаягдал булсан эсэх, энэ нь ундны ус бохирдуулсан эсэх талаархи дүгнэлтийг манай байгууллага тогтоох хууль эрх зүйн үндэслэлгүй бөгөөд бөгөөд аймгийн МХГ-аас Шаамар сумын ундны усанд бактерлогийн шинжилгээг 2 удаа , 6 байрлалд хийж, дүгнэлт гаргасан байна.

Тухайлбал, 2013 оны 06 сарын 13 –ний өдрийн 18-03-034/161 тоот дүгнэлтээр " Тус сумын эх үүсвэрийн 3 гүний худгийн усанд / *ЗДТГ-ын дэргэдэхь, МСҮТ-ийн, Зөгийн* / нян судлалын шинжилгээгээр ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 900:2005 стандартын шаардлагыг хангаж байна гэсэн бол 2014 оны 01 сарын 27-ны өдрийн 18-03-034/ 10 тоот дүгнэлтээр " хогийн цэгээс 250 м -600 м зайд, бие засах газраас 10-50 м зайд байрлах, 6-7 метрийн гүнтэй */ иргэн Г.Бат-өлзийн, Б.Гансүхийн, Төмөр замын ажилчдын* / худагнууд нь өнгө 30 буюу стандартад заасан хэмжээнээс их, булингар ихтэй, нянгийн бохирдол ихтэй байгаа нь " Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS900:2005 стандартын шаардлагыг хангахгүй байна" гэж дүгнэжээ.

Дээрхи байдлуудаас үндэслэн: **Хэдийгээр сум орон нутаг төдийгүй улс орны нүүр царай, иргэдийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлж, их хэмжээний талбай эзлэн оршиж байсан хур хогийн цэгийг цэвэрлэх бодлого барьсан нь сайн талтай ч уг ажлыг эхлэхээс өмнө холбогдох хууль тогтоомжийг бүрэн судлаагүй, гүйцэтгэх арга замаа зөв тодорхойлоогүй, иргэдийн санал бодлыг авч ИТХ-ын тогтоол, шийдвэр гаргуулаагүй, албан ёсны бичиг баримтууд нь утга санааны болон цаг хугацааны хувьд зөрчилдөж байгаа зэрэг нь сумын удирдлагууд, иргэдийн хооронд маргаан гарах нөхцөл болжээ гэж дүгнэж байна.**

Иймээс цаашид улсын хэмжээний мэргэжлийн байгууллагуудын байцаагч, шинжээчдийн багийг ажиллуулан Хогийн хонхор гэдэг газар нь ундны усны эх үүсвэр мөн эсэх, энэ нь бохирдсон эсэх, хайрга олборлосон нүхэнд хог хаягдал булсан эсэхэд нарийвчилсан шинжилгээ хийлгэж сумын удирдлага болон иргэдийн хооронд үүсээд буй маргаанд эцэслэсэн хариу өгүүлэх нь зүйтэй.

1.2 Их хэмжээний хайргыг хууль бусаар олборлосон уу?

МУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.1 *"Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэнд хяналт тавих"* гэсэн сумын ИТХ-ын бүрэн эрхийн дагуу Шаамар сумын ИТХ-аас дараах тогтоолуудыг гаргаж ажиллажээ. Үүнд:

1. Сумын ИТХ-ын 2010 оны 03-р сарын 02-ны өдрийн 01 дүгээр тогтоол *“ Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталж, түгээмэл тархацтай ашигт малтмал хайрга олборлох зориулалтаар Охиндийн 2-р багт иргэн Батжаргалын баруун урд тал, Дэлгэрхааны 1-р багт төмөр замын 49-р цэгийн зүүн талд тогтоосугай”.*

2. Сумын ИТХ-ын 2011 оны 06-р сарын 24-ны 13 дугаар тогтоол 1.“*Сумын хэмжээнд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглаж байгаа хайрганы карьеруудын ашиглалтын журамтай болтол түр хугацаагаар ашиглалтын үйл ажиллагааг зогсоосугай”*. 2. *“Үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар ашиглах карьеруудын байршил, хэмжээг сумын ИТХ-аас тогтоосон газраас хайрга олгож байх, ашиглалтын журамтай болгох арга хэмжээ авахыг сумын Засаг дарга Д.Бямбасүрэнд даалгасугай”.*

3. Сумын ИТХ-ын 2011 оны 12-р сарын 23-ны өдрийн 23 дугаар тогтоол *“ Суманд ашиглагдаж байгаа хайрганы карьеруудаас үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр өөр аймаг суманд гаргахыг хориглосугай”* гэх зэргээр тогтоол гаргажээ.

Гэтэл Шаамар сумын Засаг дарга М.Баярбаатар нь сумын ИТХ-ын дээрхи тогтоолуудыг зөрчиж хайрга олборлох, ашиглалтын журам гаргаагүй атал 2013 оны 04 сарын 29-ний өдөр “Өгөөмөр баянбулаг” ХХК-тай байгуулсан “*Төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг булуулах,хашаажуулж стандартын дагуу болгох, 1-р багийн 7,8,9-р хэсгийн дундуур сайжруулсан зам тавих, ухмалын хайрга олборлуулах”* гэрээг баталж, хайрга олборлох байршилд нэр нь заагдаагүй, өөрөөр хэлбэл хайрганы олборлолт хийх зөвшөөрөлгүй Хогийн хонхор хэмээх газраас 7874 м3 хайргыг үйлдвэрлэлийн зориулалтаар олборлуулж өөр суманд / Алтанбулаг / гаргажээ.

Шаамар сумын байгаль орчны байцаагчийн зүгээс Өгөөмөр Баянбулаг ХХК-нь 7874 м3 хайрга олборлож Алтанбулаг сум руу зөөсөн гэж бүртгэсэн хэдий ч энэ нь зөвхөн нэг талын тооцоо учир олборлолтын тоо хэмжээг баталгаажуулсан хүчин төгөлдөр нотлох баримт болж чадахгүй юм.

Хогийн хонхор хэмээх газраас хайрга олборлохоос өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсэн байх ёстой атал дараа нь нөхөн хийлгэсэн болох нь Шаамар сумаас аймгийн БОАЖГ-т явуулсан бичгийн дугаар, БОАЖГ-ын хайрга олборлох төсөлд өгсөн дугаарууд өөр бусад албан бичгүүдтэй давхцсан байгаагаас харагдаж байна. Тухайлбал, хогийн цэгээс хайрга олборлуулах байгаль орчны үнэлгээ хийлгүүлэхээр Шаамар сумын засаг даргаас аймгийн БОАЖГ-т ирүүлсэн гэх 2013 оны 04 сарын 18-ны албан бичгийн 50 гэсэн дугаар нь Шаамар сумаас 2013 оны 04 сарын 11-ны өдөр байгууллагын дарга, эрхлэгч нарт явуулсан албан бичгийн 50 гэсэн дугаартай давхцаж байсан бөгөөд үдэж архивласан баримтанд үдэгдээгүй, явсан

бичгийн завсар сул хавчуулсан байдалтай байсан юм. Шаамар сумын ЗД-ын 2013 оны 04 сарын 18-ны 1/50 тоот албан бичиг нь аймгийн БОАЖГ-ын ирсэн бичигт бүртгэгдээгүй байв.

Мөн аймгийн БОАЖГ-ын зүгээс Хогийн цэгээс хайрга олборлох төсөлд хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийн 2014 оны 04 сарын 25-ны өдрийн 12 гэсэн дугаар нь хог хаягдал цэвэрлүүлэх төсөлд өгсөн 2013 оны 5 сарын 17-ны өдрийн 12 тоот үнэлгээний дугаартай давхцаж байгаа ба үнэлгээ хийсэн үндсэн баримтууд нь байхгүй байв. Хайрга олборлох төсөлд хийсэн үнэлгээ нь БОАЖГ-ын үнэлгээний дүгнэлтийн архивт үдэж хадгалагдаагүй, завсар нь сул хавчуулсан байлаа.

Иймээс дээрхи баримтуудаас үндэслэн Шаамар сумын засаг даргын зүгээс сумын ИТХ-ын холбогдох тогтоолуудыг зөрчин хайрга олборлох байршлаар тогтоогдоогүй Шар хайлаастын хогийн цэгээс хайрга олборлох гэрээг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгүйгээр байгуулж, 7874 м3 / *сумын* байгаль орчны байцаагчийн тооцоо / хайрга олборлуулжээ гэж дүгнэж байна.

Сумын удирдлагын зүгээс ” *Шар хайлаастын хогийн цэгийг цэвэрлэх ажил нь их хэмжээний санхүүжилт , хүн хүч шаардаж байсан тул Өгөөмөр баянбулаг компаниас хог цэвэрлэх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж хариуд нь тус газраас үнэ төлбөргүй хайрга олборлох санал ирүүлснийг үндэслэлтэй гэж үзэн гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн*" гэж байгаа ч өөр хоорондоо холбоотой уг 2 ажлыг эхлүүлэхээс өмнө сумын ИТХ-аас шийдвэр гаргуулж, байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй хийгдэх арга замыг зөв тодорхойлж, нэгдсэн үнэлгээ хийлгүйлээгүйгээс холбогдох хууль, тогтоомж, журмыг зөрчжээ.

1.3 “Гүн жоос” ХХК нь Шаамар сумын Хогийн хонхор болон 30-н тохой хэмээх газруудаас их хэмжээний хайргыг хууль бусаар олборлосон уу?

Аудитын явцад Гүн жоос ХХК-нь Хогийн хонхор болон 30-ын тохой гэдэг газраас их хэмжээний хайрга олборлосон эсэхийг шалгаж үзэхэд өргөдөл гаргагч иргэдийн 30-ын тохой гэдэгт хийсэн бичлэгээс өөр нотлох ямар нэгэн баримт илэрсэнгүй. Тус бичлэг нь Гүн жоос компаний захирал Жаргалсайхан нь бригад гаргаж 30-ын тохойд ажиллаж байгааг харуулсан байсныг өөрөөс нь лавлан асуухад:

“Миний бие нь Шаамар сумын Хогийн хонхороос хайрга огт олборлоогүй, харин 2013 оны 07-р сарын 08-ны өдөр орон нутгийн орлогын дансанд 400,0 мянган төгрөгийг тушааж Батжаргалын баруун урд байрлалтай хайрганы карьераас 200 м3 хайрга олборлож ахуйн хэрэгцээндээ зарцуулсан. 30-ын тохой гэдэг газраас ч хайрга

олборлоогүй, харин Сүхбаатар сумын “Виду” ХХК-ны хайрга олборлосон газарт тэдний хүсэлтээр нөхөн сэргээлт хийж 3000,0 мянган төгрөгийг ажлын хөлсөнд авсан. Биднийг нөхөн сэргээлт хийж байхад өргөдөл гаргасан иргэд ирж бичлэг хийж байсан, уг бичлэгт хайрга ачаад зөөж байгаа ямар ч баримт байхгүй, хэрэв зөөсөн бол тэдний бичлэгт тодорхой гарах байсан” гэж тайлбарлаж байсан бол “Виду” ХХК –ны удирдлагын зүгээс: “ Манай компани нь 2013 онд Сүхбаатар суманд 112 айлын орон сууцыг барьж ашиглалтанд оруулсан бөгөөд уг барилгын ажилд шаардлагатай 300-350 м3 голын хайргыг 30-ын тохой хэмээх газраас олборлосон. Олборлолт хийсний дараа Шаамар сумын иргэн О.Жаргалсайхантай тохирч нөхөн сэргээлтийн ажлыг хийлгүүлэн ажлын хөлсөнд нь 3000,0 мянган төгрөг өгсөн ” гэсэн тайлбарыг 2013 оны 02-р сарын 21-ний өдрийн 17 тоот албан бичгээр тайлбар ирүүлсэн болно.

Мөн О.Жаргалсайхан нь Шаамар сумын иргэний хувиар ахуйн зориулалттай хайрга олборлохоор сумын орлогод 400,0 мянган төгрөг төвлөрүүлж, ИТХ-аас зөвшөөрөгдсөн Батжаргалын баруун урд байрлалтай карьераас 200 м3 хайрга олборлож ахуйн хэрэгцээнд ашигласан гэдэг тайлбарыг сумын байгаль орчны байцаагч өгч байлаа. Иймээс Гүн жоос ХХК нь Шаамар сумын Хогийн хонхор болон 30-ын тохой гэдэг газраас хууль бусаар хайрга олборлосон эсэхийг Аудитын газар дүгнэх боломжгүй юм.

1.4 Сумын Засаг дарга М.Баярбаатар нь хууль бусаар хайрга олборлон “Гүн жоос” ХХК-иар өөрийн хашаандаа их хэмжээний хайрга буулгуулсан эсэх.

Шаамар сумын ИТХ-ын 2009 оны 09-р сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх түгээмэл тархацтай байгалийн баялаг болон байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг баталсан бөгөөд голын 1 м3 хайрганы үнийг орон нутгийн иргэн 200 төгрөгөөр, аж ахуйн нэгж, гадны иргэн 2500 төгрөгөөр олборлохоор тогтоосон байна.

Тус сумын Засаг дарга М.Баярбаатараас асуулга авахад:” *Миний бие нь иргэний хувьд хувийн хашаагаа блокоор шинэчлэх зорилгоор 2013 оны 07 сарын 23-ны өдөр орон нутгийн орлогын дансанд 45,0 мянган төгрөг тушааж сумын ИТХ-аас зөвшөөрөгдсөн Батжаргалын баруун урд байрлалтай хайрганы карьераас 22,5 м3 хайрга олборлосон болно. Хайрга зөөх машингүй тул “Гүн жоос” ХХК-ий захирал О.Жаргалсайханы машинаар гэрийнхээ гадна буулгуулаад өнөөг хүртэл ашиглаагүй*” гэж тайлбарлаж байсан бөгөөд аудитын явцад газар дээр нь очиж үзэхэд М.Баярбаатарын хашааны гадна буулгуулсан гэх , 2 машин орчим хайрга овоолгоотой байлаа.

Тиймээс сумын засаг дарга М.Баярбаатар нь хууль бусаар их хэмжээний хайрга олборлосон гэж үзэхгүй байна.

2.Орон нутгийн хөгжлийн сан болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжуудын дагуу зарцуулсан эсэх.

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байна уу.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 60.1- д заасан "*Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна"* гэсэн бүрэн эрхийн дагуу 2013 онд аймгийн ОНХС-гаас тус суманд хуваарилагдсан хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөг сумын ИТХ-д өргөн мэдүүлснийг сумын ИТХ-ын 2013 оны 01-р сарын 23-ны өдрийн 11 дугаар тогтоолоор дараахь ажлуудыг гүйцэтгэхээр баталжээ.Үүнд:

1. Дулаанхаан тосгонд Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга угсралт. Төсөвт өртөг 80000,0 мянган төгрөг
2. Шаамар суманд Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга угсралт. Төсөвт өртөг 80000,0 мянган төгрөг
3. Шаамар суманд Наадмын талбайн барилга байгууламж. Төсөвт өртөг 20395,7 мянган төгрөг.

Гэтэл Шаамар сум болон Дулаанхаан тосгонд Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлыг УТХО-аар гүйцэтгэх болсон тул сумын ИТХ-ын 2013 оны 04-р сарын 05-ны өдрийн 26 дугаар тогтоолоор дээрх жагсаалтыг шинэчлэн баталсан байна.Үүнд:

1.Дулаанхаан тосгонд Төрийн албан хаагчдын 6 айлын орон сууц.Төсөвт өртөг 80000,0 мянган төгрөг.

2.Шаамар суманд Наадмын талбайн барилга байгууламж.Төсөвт өртөг 70395,7 мянган төгрөг. Нийт 150395,7 мянган төгрөг төсөвлөгдсөн бөгөөд уг барилга угсралтын ажлуудын зураг, төсвийг "Талхун арал" ХХК-иар гэрээний дагуу гүйцэтгүүлжээ.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх дээрхи 2 барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2013 оны 08-р сарын 27-ны өдрийн А/174 болон А/175 тоот захирамжуудаар тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар баригдсан Наадмын талбайн барилга байгууламжийн хяналтын төсөв 79806,5 мянган төгрөгөөр, Дулаанхаан тосгоны 6 айлын орон сууцны хяналтын төсөв 77926,6 мянган төгрөгөөр тус тус хийгдсэн тул МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33.1 дэх *"Бараа, ажил, үйлчилгээний төсөвт*

өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” -ын дагуу харьцуулалтын аргыг ашиглан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байлаа.

МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33.2.1 дэх *“Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх*” гэсэн заалтын дагуу Наадмын талбайн барилга угсралтын гүйцэтгэгчээр ажиллах урилгыг Зочу Сэлэнгэ, Есөн хэлхээ, Сэлэнгэ таван хан копаниудад хүргүүлэхэд Зочу Сэлэнгэ ХХК -нь боломжгүй тухай албан тоот ирүүлж сонгон шалгаруулат Сэлэнгэ таван хан, Есөн хэлхээ ХХК-иудын хооронд болж Сэлэнгэ Таванхан ХХК 69936,8 мянган төгрөгийн үнийн санал ирүүлэн гүйцэтгэгчээр шалгарч 2013 оны 08-р сарын 16-ны өдөр СЭА-ШНТ 04/2013 дугаартай гэрээ байгуулсан байна. Гэрээ ёсоор Сэлэнгэ таван хан ХХК нь барилгын ажлыг барилгын зураг, төсөв, гэрээний дагуу хийж гүйцэтгэн 2013 оны 09-р сарын 16-ны өдөр ашиглалтанд хүлээлгэн өгөх ёстой боловч өнөөг хүртэл барилга байгууламжийг ашиглалтанд оруулж улсын комисст хүлээлгэн өгөөгүй учир уг компаниар гэрээт ажлыг ирүүлсэн үнийн саналд нь багтаан яаралтай гүйцэтгүүлэх шаардлагатай. Гүйцэтгэгч компани гэрээт ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн нь хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

ОНХС-гийн хөрөнгөөр Дулаанхаан тосгонд баригдах энгийн галлагаатай 6-н айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэгчээр ажиллах урилгыг Мөнгөн Өргөө, Тэнгэрийн баримал, Хангол мандал компаниудад өгсөн бөгөөд Хангол мандал ХХК нь баримт материалыг хугацаа хоцроож шалгаруулалтаас хасагдсан учир сонгон шалгаруулалт Тэнгэрийн баримал ХХК , Мөнгөн Өргөө компаниудын хооронд болж 76031,5 мянган төгрөгийн санал ирүүлсэн Тэнгэрийн баримал ХХК –ийг гүйцэтгэгчээр шалгаруулан 2013 оны 09-р сарын 09-ны өдөр СЭА-ШБ 03/2013 дугаартай гэрээ байгуулжээ. Гэвч Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт бүртгэлтэй, барилгын ажил эрхлэх “Тусгай зөвшөөрөл”-гүй Тэнгэрийн баримал компанид урилга хүргүүлж, гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан тул уг компани нь барилгын ажлын тусгай зөвшөөрөлтэй Мөнх-Од компанитай түншлэлийн гэрээ байгуулж барилгын ажлыг гүйцэтгүүлэн 2013 оны 12 сарын 10-ны өдрийн 02 тоот актаар ашиглалтанд хүлээн авсан байна. Барилгын ажлын тусгай зөвшөөрөлгүй компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 12.2 дахь заалт *“Захиалагч тухайн тендер шалгаруулалтанд тавигдах чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана”* гэсэн заалтыг зөрчихөд хүргэжээ.

1.2 Улс,орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх.

2.2.а Сумын төвд сайжруулсан зам тавих ажлыг гэрээний заалтын дагуу Өгөөмөр Баянбулаг компаниар гүйцэтгүүлэх атал орон нутгийн төсвөөс 13200,0 мянган төгрөгийг зарцуулсан уу.

Өгөөмөр баянбулаг ХХК-тай байгуулсан 2013 оны 04-р сарын 29-ын өдрийн 01 тоот гэрээнд "Сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг булуулах, хашаажуулж, стандартын дагуу болгох, 1-р багийн 7,8,9 –р хэсгийн дундуур сайжруулсан зам тавих, ухмалын хайрга олборлох" гэрээний 3.4-д"... зам тавих...", 3.5-д *"Замын өргөн 6 м, зузаан нь 20 см байна"* , мөн 3.8-д "*Сайжруулсан зам тавих, хашаа барихтай холбогдсон зардлыг Өгөөмөр баянбулаг ХХК хариуцах бөгөөд өргөн тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр төлөхгүй болно"* гэж тодорхой заасан байдаг.

Гэтэл "Өгөөмөр баянбулаг" ХХК нь замын ажилд хэрэглэх уулын хайргыг Алтанбулаг сумаас Шаамар суманд зөөвөрлөн авчирсан бөгөөд гэрээнд дурьдсан 6 м-ийн өргөнтэй, 20 см-ийн зузаантай замын ажлыг бүрэн гүйцэтгээгүй байна.

Харин уг гэрээнд заагдсан замын ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 13200,0 мянган төгрөгийн өртгөөр Сэлэнгэ АЗЗА компаниар гүйцээлгэн хийлгэжээ./ *2,1 км зам* /

Иймээс зам тавихад нэмж зарцуулсан 13200,0 мянган төгрөгийг Өгөөмөр баянбулаг ХХК-иар нөхөн төлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

2.2.б.Сумын Засаг дарга М.Баярбаатар нь 2007 онд аймгийн хөрөнгө оруулалтаар сумын иргэд, ААН-д гэрээгээр ашиглуулахаар хуваарилагдсан Сүү хөргөх төхөөрөмжийг өөрийн компанийн нэр дээр авч улмаар дамлан худалдаж Кубота маркийн трактороор сольж авсан эсэх.

"Сумын амьжиргааг дэмжих сан"-гийн даргаар ажиллаж байхдаа өөрөө өөртөө гарын үсэг зурж 10000,0 мянган төгрөгийг авч ашигласан уу.

2011 онд аймгийн ИХТөлөөлөгч байхдаа "Үр шинэчлэл" төслийн хүрээнд суманд хуваарилагдсан 34000,0 мянган төгрөгийг хувьдаа авсан эсэх.

Шаамар сумын Засаг дарга М.Баярбаатар нь "Буман буудай" ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа "Бороо гоулд" ХХК-ний хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн сумдад хуваарилагдсан 10550,0 мянган төгрөгийн өртөг бүхий сүү хөргөх тоног төхөөрөмжийг 2008 оны 10-р сарын 30-ны өдөр "Халиун-Уул" ХХК-иар дамжуулан авчээ. Уг сүү хөргөх төхөөрөмжийг ямар нэгэн аж ахуйн нэгж, хувь хүний хувийн өмчлөлд шилжүүлээгүй, тус сумын иргэдийн үйлдвэрлэсэн сүүг хөргөх, борлуулах зорилгоор нийтийн хэрэгцээнд олгосон орон нутгийн өмч учир сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэж, тухайн суманд ашиглаж байх учиртай. Иймээс сүү хөргөх тоног төхөөрөмжийг худалдан борлуулсан талаар хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх нь зүйтэй.

М.Баярбаатар нь Шаамар сумын "Амьжиргааг дэмжих сан"-гийн даргаар ажиллаж байхдаа 2008 оны 04-р сарын 01-ны өдөр 5000,0 мянган төгрөгийг түр хугацаанд

зээлээр авч ашиглан 2008 оны 09-р сарын 17-ны өдөр буцаан төлснийг бид аудитын явцад Сэлэнгэ аймгийн Төрийн банкны хуулгын баримтаар баталгаажуулсан болно.

“Төмс, хүнсний ногоо хөтөлбөр”-ийн хүрээнд 2011 онд аймгийн ЗДТГ-т 17 сумын иргэдээс төмс, хүнсний ногоо тариалах 129 төсөл ирүүлснээс 110 төсөл дэмжигдэж нийт 397800,0 мянган төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр олгожээ.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд Шаамар сумын 21 иргэдээс нийт 115900,0 мянган төгрөгийн төсөл ирүүлсэний 16 иргэний төсөл дэмжигдэн 34500,0 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн Төрийн сангаас иргэдийн харилцах дансаар дамжуулан олгосон байна.

Дэмжигдсэн төсөлд олгосон санхүүжилтийн жагсаалт / мян төг/

№	Төсөл хэрэгжүүлэгч	Төслийн нэр	Төслийн мөнгөн дүн		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
			Хүссэн	Олгосон	
1	М.Баярмаа	Амар	20000,0	5000,0	Байгалийн цэвэр, органик эрүүл хүнс
2	Т.Өлзийжаргал	Газрын шим	2400,0	1500,0	Нарийн ногоо тариалах
3	Д.Мөнхцэцэг	Ургац	3000,0	1500,0	Хүнсний ногоо тариалах
4	Ц.Баярсайхан	Арвин ургац	6000,0	1500,0	Хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх
5	Н.Наранчимэг	Төмс	5000,0	1500,0	Төмс, хүнсний ногоо тариалах
6	Б.Ууганбаатар	Алтан намар	1500,0	1500,0	Төмс, хүнсний ногоо тариалах
7	Д.Баатарцоож	Ургацын амт	5000,0	1000,0	Төмс, хүнсний ногоо тариалах
8	М.Баярбаатар	Монгол төмс	8500,0	4000,0	Махлаг шар төмс тариалах
9	Ахан дүүс /Ц.Цэнгэл/	Хүлэмжийн аж ахуй	2500,0	1500,0	Цэвэр бөөрөнхий сонгино тариалах, үрийн нөөцтэй болох
10	Д.Бямбасүрэн	Хүлэмжийн аж ахуй	5000,0	1500,0	Хүлэмжийн аж ахуй
11	Б.Энхболд	Хүлэмжийн аж ахуй	5000,0	1000,0	Хүлэмжийн аж ахуй
12	Д.Шура	Газрын өгөөж	5000,0	1000,0	Хүлэмжийн аж ахуй
13	Жимсгэнэ бүл	Хүлэмжийн аж ахуй	3000,0	3000,0	Хүлэмжийн аж ахуй
14	Н.Мучаа	Зоорийн аж ахуй	8000,0	4000,0	30 тн-н зоорь барих
15	Шар тохой бүл	Хүлэмжийн аж ахуй	5000,0	2000,0	Хүнсний ногоо тариалах
16	Г.Болдбаяр	Төмс	3000,0	3000,0	Хүнсний ногоо тариалах
	ДҮН		**87900,0**	**34500,0**	

М.Баярбаатар нь Шаамар сумын иргэний хувьд “Махлаг шар төмс тариалах” 8500,0 мянган төгрөгийн төсөл ирүүлснээс 4000,0 мянган төгрөг олгожээ.

2.2.в. Сумын Засаг дарга нь ИТХ-ын даргатайгаа үгсэн хуйвалдаж ИТХ-ын даргын нэр дээр байдаг аж ахуйн нэгжид төсвөөс 11000,0 мянган төгрөг олгуулсан эсэх.

Шаамар сумын ИТХ-ын даргаар ажиллаж байгаа О.Эрдэнэчимэг нь уг албан тушаалыг хашихаас өмнө “Өсөх эрдэнэт сүрэг” БГБХ нөхөрлөлийн захирлаар ажиллаж байсан бөгөөд 2013 оны 03-р сарын 13-ны өдөр Ж.Итгэлт гэдэг хүний нэр дээр удирдлагын өөрчлөлтийг шилжүүлж Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэн

баталгаажуулсан байна. Гэвч 2013 оны 04-р сарын 08-ны өдөр аймгийн ХХААЖДҮГ-ын дарга Х.Даваахүү, Шаамар сумын Засаг дарга М.Баярбаатар нартай байгуулсан гурвалсан гэрээнд аж ахуйн нэгжийн захирал гэж өөрийн нэрээр гарын үсэг зурж баталгаажуулжээ. Энэ нь МУ-ын НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 20.1 дэхь" Албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Тус ХХК нь гэрээнд заасан эрх , үүргийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгэж, ажлын тайланг аймгийн ХХААЖДҮГ-ын Мал эмнэлгийн газарт ирүүлэн 2013 онд 11576,0 мянган төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд өргөдөлд дурьдсанчлан сумын хөрөнгөнөөс ямар нэгэн санхүүжилт хийгдээгүй байна.

3.Авлигын эсрэг болон НАНБХАСЗАСЗУСТ хуулийн хэрэгжилтийг хангаж байна уу.

3.1 Сумын засаг даргын албан тушаалд томилогдохын тулд холбогдох хүмүүст албан тушаал амлаж, саналыг нь худалдаж авсан эсэх.

Сумын засаг даргаар томилогдон ажиллаж байгаа М.Баярбаатар нь уг албан тушаалыг хашихын тулд сумын ИТХ-дахь Ардчилсан намын төлөөлөгч болох Мягмартогтох, Цогтбаяр нарт төрийн ажил амлаж саналыг нь худалдан авсан эсэх, энэ нь МУ-ын Авлигын эсрэг хуулийн 7.1.2-р зүйлийг зөрчиж байгаа эсэхэд Аудитын газар дүгнэлт өгөх боломжгүй учир хууль, хяналтын байгууллагуудад хандах нь зүйтэй.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

Ерөнхий дүгнэлт:

Хогийн хонхорын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах, уг газраас хайрга олборлох ажлыг эхлүүлэхээс өмнө холбогдох хууль тогтоомжийг бүрэн судлаагүй, өөр хоорондоо холбоотой 2 ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг нэгтгэж авч үзээгүй, сумын ИТХ-аас шийдвэр гаргуулж, гүйцэтгэх арга замаа зөв тодорхойлоогүй болон албан ёсны бичиг баримтууд утга санаа, цаг хугацааны хувьд зөрчилдөж байгаа зэрэг нь сумын удирдлагууд, иргэдийн хоорондмаргаан гарах нөхцөлийг үүсгэжээ.

Иймээс улсын хэмжээний мэргэжлийн байгууллагуудын байцаагч, шинжээчдийн багийг ажиллуулан Хогийн хонхор гэдэг газар нь ундны усны эх

үүсвэр мөн эсэх, энэ нь бохирдсон эсэх, хайрга олборлосон нүхэнд хог хаягдал булсан эсэхэд нарийвчилсан шинжилгээ хийлгэж үүсээд буй маргаанд эцэслэсэн хариу өгүүлэх нь зүйтэй.

Ерөнхий дүгнэлтийг задлан харуулбал:

1. Сумын ИТХ-ын зүгээс тус сумын нутаг дэвсгэрт байгалийн баялагийг ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдолтой хууль тогтоомж, ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
2. Сумын ИТХ-нь сумын Засаг дарга, ЗДТГ-ын зүгээс байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг ашиглах, нөхөн сэргээх талаар хийж гүйцэтгэж буй ажилд үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.
3. Суманд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих үүрэгтэй байгаль орчны улсын байцаагч үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
4. Өгөөмөр баянбулаг ХХК- тай байгуулсан албан ёсны гэрээ нь Хогийн хонхороос хайрга олборлож, үүссэн нүхэнд хог хаягдлыг булахаар хийгдэж гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байна.
5. Дээрхи гэрээг залруулж хийгдсэн гэх гэрээ нь гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй байна.
6. Хогийн хонхорын хур хог хаягдлыг түрж цэвэрлэн зөөвөрлөж ,том, жижиг олон тооны овоолго болгосон бөгөөд их, бага хэмжээгээр нүхэнд булсан эсэх нь тодорхойгүй байна.
7. Сумын ИТХ-аар байршил тогтоогдоогүй Хогийн хонхор хэмээх газраас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ хийлгүүлэлгүйгээр хайрга олборлосон байна.
8. Өгөөмөр баянбулаг ХХК –нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хайрган хучилттай замын ажлыг бүрэн гүйцэд хийгээгүй байна.
9. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчээр барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлгүй Тэнгэрийн баримал компанийг сонгосон байна.
10. Сэлэнгэ Таван хан компани нь гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн байна.

Дөрөв. АЛДАА ЗӨРЧИЛ

Нийцлийн аудитаар дараахь зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ.

1.Төлбөрийн акт:

- Сайжруулсан хайрган зам тавих ажлыг гүйцээж дуусгахад төсвөөс зарцуулсан 13200,0 мянган төгрөгийг Өгөөмөр баянбулаг компаниар нөхөн төлүүлэх.

2.Албан шаардлага:

- Хогийн хонхор гэдэг газар нь ундны усны эх үүсвэр мөн эсэх,хайрга олборлосон нүхэнд хог хаягдал булсан эсэх, ундны ус бохирдсон эсэхэд улсын хэмжээний мэргэжлийн байгууллагуудаар шинжилгээ хийлгэж , хариуг иргэдэд мэдээлэх.
- ИТХ-ын холбогдох тогтоолуудыг зөрчин хайрга олборлох байршлаар тогтоогдоогүй Шар хайлаастын хогийн цэгээс хайрга олборлох гэрээг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгүйгээр байгуулж, 7874 м3 / *сумын* байгаль орчны байцаагчийн тооцоо / хайрга олборлуулсан сумын засаг дарга М.Баярбаатарт хариуцлага тооцох.
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр барилгын ажлын тусгай зөвшөөрөлгүй Тэнгэрийн баримал компанийг сонгон шалгаруулсан ажлын хэсгийн ахлагчид хариуцлага тооцох.

Тав. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Шаамар сумын ИТХ-ын дарга О.Эрдэнэчимэг-т:

1. Сумын нутаг дэвсгэрт байгалийн баялагийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, төсөв, санхүү, хөрөнгө мөнгөний зарцуулалттай холбоотой хууль тогтоомж, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах.
2. Сумын Засаг дарга, ЗДТГ-ын зүгээс гүйцэтгэж буй байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаа болон хөрөнгө мөнгөний зарцуулалтанд үнэлэлт дүгнэлт өгч, буруутай гэж үзвэл таслан зогсоох.

Шаамар сумын Засаг дарга М.Баярбаатар-т:

1. Сумын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн түгээмэл тархацтай баялагийн ашиглалтанд холбогдох хууль тогтоомж, аймаг, сумын ИТХ-ын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.
2. Байгалийн баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төсөв, санхүү, хөрөнгө мөнгөний зарцуулалтын талаар сумын ИТХ-д тайлагнаж байх.
3. Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг бүрэн авсан боловч гэрээт хугацаанд нь ашиглалтанд оруулж улсын комисст хүлээлгэн өгөөгүй Сэлэнгэ Таван хан компаниар уг ажлыг бүрэн гүйцэтгүүлэх.
4. Төсвийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу зарцуулах.

Шаамар сумын төрийн сангийн төлөөлөгч Д.Энхбаяр-т:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтэнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэх.
2. Батлагдсан төсвөөс гадуур гүйлгээ хийхгүй байх, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

ШИНЖЭЭЧ С.БААСАНСҮРЭН

МУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төслийг 2014 оны 26 –нд Шаамар сумын удирдлагуудад хүргүүлсэн бөгөөд тайлангийн төсөлд тайлбар гаргаж Сэлэнгэ аймгийн Аудитын газарт 2014 оны 02 сарын 28-д ирүүлсэн болно

Шаамар сумын Засаг дарга М.Баярбаатар, ЗД-ын орлогч С.Мягмартогтох, байгаль орчны улсын байцаагч С.Пэрэнлэй нарын ирүүлсэн саналд аймгийн Аудитын газраас дараахь тайлбарыг хийж байна.

М.Баярбаатарын санал:

1.“Засаг дарга асан Д.Бямбасүрэнгийн 2012 онд Өгөөмөр баянбулаг компанитай гэрээ байгуулж эхлүүлсэн ажлыг иргэдийн зүгээс ус бохирдуулж байна гэсэн эсэргүүцэл гаргаж зогсоосныг М.Баярбаатар дарга дахин эхлүүлэх зорилгоор гэрээ байгуулсан гэж тайлангийн төсөлд тусгажээ. Гэвч 2012 хийгдэж байсан ажил нь ус бохирдуулсан гэж гаргасан эсэргүүцлээс болж зогсоогүй. Харин Д.Соёлбаатар өөрийн эзэмшдэг хайрганы карьераас Өгөөмөр баянбулаг компанид хайрга нийлүүлүүлэх зорилгоор зам эвдэж, тоос босгож байна гэж эсэргүүцснээс болж зогсоосон. Үүнийг залруулж өгнө үү” гэжээ.

Аудитын газрын тайлбар:

1.Аудитын явцад засаг дарга асан Д.Бямбасүрэнгээс асуулга авахад “ Уг ажлыг 2012 онд дөнгөж эхлүүлж байтал иргэдийн зүгээс эсэргүүцэл гаргасан учир зогсоосон” гэсэн тайлбар өгч байсан. Иймээс эсэргүүцэл гаргасан нь үнэн боловч шалтгааныг нь ус бохирдуулсан гэж бичсэнийг тайланд залруулав.

М.Баярбаатарын санал :

2. “Анхны гэрээний дагуу “ Хог булшлах “ ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ хийлгүүлэхээр БОАЖГ-т бичиг хүргүүлсэн нь үнэн. Гэхдээ хог хаягдлыг цэвэрлэхийн өмнө гэрээнд засвар оруулж ” Хог хаягдлыг нүх ухаж булшлах” гэдгийг далан босгож овоолго хийх” гэж залруулсан .Баяр наадам дөхөж байсан учраас дүгнэлт гарахаас өмнө эхлүүлсэн нь бидний буруу, бид хогийг ухсан нүхэнд булаагүй, далан босгож овоолсон. Хуучин гэрээний нүх ухаж булшлана гэдэг заалтыг барьж дүгнэлт хийснийг залруулж өгнө үү” гэжээ.

Аудитын газрын тайлбар:

2.Аудитын явцад сумын засаг дарга М. Баярбаатар бидэнд анхны гэрээ болон залруулсан гэх гэрээг алиныг нь ч өгөөгүй. Харин өргөдөл гаргагч талаас засаг дарга М.Баярбаатар болон ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан н.Мөнхзул нарын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан " Төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг булуулах, хашаажуулж стандартын дагуу болгох, 1-р багийн 7,8,9-р хэсгийн дундуур сайжруулсан зам тавих, ухмалын хайрга олборлох гэрээ" –г канондсон хуулбарыг авчирч өгсөнийг ЗДТГ-ын дарга асан н.Мөнхзулаас тодруулахад " ийм гэрээ байгуулсан нь үнэн" гэж тодорхойлолт бичиж өгсөн. Засаг дарга М. Баярбаатарын дараа нь залруулж байгуулсан гэх гэрээ нь ямар ч гарын үсэг зурагдаагүй, тамга тэмдэг дарагдаж баталгаажаагүй учир хүчин төгөлдөр баримт бичиг гэж үзэх үндэслэлгүй юм. Бид аудитын явцад Хогийн хонхорт очиж үзэхэд хог хаягдлыг зөөж тээвэрлэн олон тооны овоолго үүсгэсэн байсан нь үнэн, хайрганы нүхэнд хог булсан эсэх нь тодорхойгүй талаар тайлангийн төсөлд дурьдсан болно. Манай тайлангийн төсөлд хогийг нүхэнд булсан, ус бохирдуулсан гэж огт бичигдээгүй, манай байгууллага үүнийг тодорхойлох хууль эрх зүйн үндэсгүй учир мэргэжлийн байгууллагуудаар шинжилгээ хийлгэж иргэдэд мэдээлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

Залруулсан гэх гэрээг хүчин төгөлдөр баримт бичиг гэж үзэх үндэслэлгүй учир түүнийг үндэслэл болгож залруулах боломжгүй.

М.Баярбаатарын санал:

3." Би гэрийнхээ гадаа 2 машин хайрга буулгасан, үүнийг 225 м3 гэж бичсэнийг залруулна уу"

Аудитын газрын тайлбар:

3.Тайлангийн төсөлд таслал алдаж 225 м3 гэснийг 22,5м3 гэж болгож залруулав.

М.Баярбаатарын санал:

4" .Дүгнэлтэнд Хог хаягдлыг газар ухаж булшлах үйл ажиллагаанд иргэдийн зүгээс эсэргүүцэл үзүүлж зогсоосон тул хогийн овоолго болгон зөөвөрлөсөн байна " гэж бичсэнийг залруулж өгнө үү"

Аудитын газрын тайлбар:

4. Хогийн хонхорын хур хог хаягдлыг түрж цэвэрлэн зөөвөрлөж ,том, жижиг олон тооны овоолго болгосон бөгөөд их бага хэмжээгээр нүхэнд булсан эсэх нь тодорхойгүй учир Хогийн хонхор гэдэг газар нь ундны усны эх үүсвэр мөн эсэх, хайрга олборлосон нүхэнд хог хаягдал булсан эсэх, энэ нь ус бохирдуулсан эсэхэд улсын хэмжээний мэргэжлийн байгууллагын зүгээс шинжилгээ хийлгэх шаардлагатай байна."гэж залруулав.

М.Баярбаатарын санал:

5.Манай компанид олгосон сүү хөргөх төхөөрөмжийг ямар үндэслэлээр ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд авах гэж байгааг ойлгохгүй байна. Хэрэв энэ асуудлыг ийм байдлаар шийдэж байвал бүх суманд олгосон төхөөрөмжүүдийг тухайн сумын ЗДТГ-т бүртгэх хэрэгтэй" гэжээ

Аудитын газрын тайлбар:

5.Уг төхөөрөмжийг танай компанид Халиун-УУЛ компаниас өгөөгүй, харин Бороо гоулд компаний хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн иргэдийн хэрэгцээнд олгосныг Халиун-Уул компаний агуулахад хадгалуулж байгаад аймгийн засаг даргын зөвшөөрлөөр танай компанид " Шаамар суманд ажиллуулж иргэдийн хэрэгцээг хангаж байх зорилгоор "олгосон учир компаний хөрөнгө биш гэж үзэж байна. Хэрэв танай компани уг төхөөрөмжийг ажиллуулж чадахгүй бол Шаамар суманд ажиллуулах өөр иргэн ,аж ахуйн нэгжид шилжүүлэх нь зүйтэй. Зарж борлуулах эрх байхгүй болно.

С.Мягмартогтохын санал:

6.Шаамар суманд 2013 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 2 ажил нь нээлттэй тендер шалгаруулах босго үнээс хэтрээгүй, өөрөөр хэлбэл 80,0 саяын босго үнэнд багтсан, харьцуулалтын арга хэрэглэсэн учир үнэлгээний хороо байгуулаагүй, ажлын хэсэг байгуулсан. Энэ тохиолдолд худалдан авах ажиллагааны чиглэлээр ззаавал мэргэшсэн байх хуулийн заалт үйлчлэхгүй учир залруулж өгнө үү " гэжээ.

Аудитын газрын тайлбар:

6.Аудиторын буруугаас ийм дүгнэлт хийгдсэнийг залруулав.

С.Пэрэнлэйгийн санал:

7.Сумын ИТХ-р байршил нь тогтоогдоогүй Хогийн хонхор хэмээх газраас байгаль орчны үнэлгээ хийлгүүлэлгүйгээр хайрга олборлосон байна гэж дүгнэсэн байна. Тухайн үед үнэлгээ хийгдсэн нь үнэн, албан тоотын болон, үнэлгээний дугаар давхардсан нь мэргэжилтний алдаа учир залруулж өгнө үү" гэжээ.

Аудитын газрын тайлбар:

7.Нотлох баримтаар байгаль орчны үнэлгээ нь хайрга олборлосноос хойш , бүр 2013 оны бүх бичиг баримт архивлагдаж үдэгдсэний дараа хийгдэж сул хавчуулагдсан нь Шаамар сумын болон БОАЖГ-ын 2 талын албан бичгээс нотлогдсон учир засварлах боломжгүй.

С.Пэрэнлэйгийн санал:

8. "Байгуулсан гэрээ нь анхнаасаа хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх бус хайрга олборлох, үүссэн нүхэнд хог хаягдал булах зорилготой байсныг тодорхойлж байна гэсэн дүгнэлтийг Өгөөмөр баянбулаг компаний удирдлага, ажилчдаас асуулга авч залруулж өгнө үү" гэжээ.

Аудитын газрын тайлбар:

8.Бид гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан албан ёсны гэрээ, баримт бичигт үндэслэн дүгнэлтээ гаргасан. Гэхдээ хогийг овоолго болгон түрж цэвэрлэсэн нь үнэн болно, харин ухагдсан нүхэнд хог хаягдал булсан эсэх, ус бохирдсон эсэх нь тодорхойгүй, иймээс мэргэжлийн байгууллагуудаар дүгнэлт хийлгэж иргэдийн зүгээс гарсан маргаанд хариулт өгөх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг өгсөн учир залруулах боломжгүй.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА
ШИНЖЭЭЧ С.БААСАНСҮРЭН